



ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ

СОНГУУЛИЙН ҮЕИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ЁС ЗҮЙ

Мониторингийн тайлан

**СОНГУУЛИЙН ҮЕИЙН ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
БА ЁС ЗҮЙ**

Улаанбаатар 2020

Энэхүү мониторингийг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захиалгаар хараат бус судлаачид гүйцэтгэсэн бөгөөд тайланд дурдагдсан агуулга нь ХМЗ-ийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

Д.Пунсанцогвоо Судалгааны багийн ахлагч, социологич

А.Амартүвшин Сэтгүүлч, судлаач

Л.Галбаатар Хуульч, хараат бус судлаач

О.Дүүрэнжаргал Туслах судлаач

Б.Пүрэвсүрэн Хуульч, хараат бус судлаач

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	6
Нэг. Мониторингийн зорилго, аргачлал	7
Хоёр. УИХ-ын сонгуулийн жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлт	11
Гурав. Телевизүүд сонгуулийн хугацаанд сэтгүүл зүйн үүргээ биелүүлсэн үү?	26
Дөрөв. Зөвлөмж	52
Тав. Ашигласан эх сурвалжийн жагсаалт	55
Зургаа. Хавсралт	56

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
МУЕПГ	Монгол улсын ерөнхий прокурорын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөөх газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ХМЗ	Хэвлэл мэдээллийн зөвлөл
УБ	Улаанбаатар
ТВ	Телевиз
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын их хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
УОК	Улсын онцгой комисс
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага

Нэг. Мониторингийн зорилго, аргачлал

Мониторингийн зорилго

УИХ-ын 2020 оны сонгуулийн жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох эрх зүйн маргаан, зөрчлийн хэргийн шийдвэрлэлт болон сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хугацаанд хэвлэл мэдээллийн байгууллагууд (өргөн нэвтрүүлгийн телевизүүд) сэтгүүл зүйн мэргэжлийн үүргээ хэрхэн биелүүлсэнд хөндлөнгийн мониторинг хийж, дүгнэлт гаргахад чиглэнэ.

Дээрх зорилгыг хангахын тулд хараат бус хөндлөнгийн судлаачид дараах хоёр төрлийн мониторингийг 2020 оны 8-10 дугаар сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Мониторингийн аргачлал

1) Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлтийн тоон мониторинг

УИХ-ын 2020 оны сонгуулийн үед хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Үүнд:

- Сонгуулийн тухай хууль (46 болон 48 дугаар бүлэг)
- Эрүүгийн хууль (13.14 болон 14.18 дүгээр заалт)
- Зөрчлийн тухай хууль (5.13.1 дэх заалт)
- Гамшгаас хамгаалах тухай хууль (10.4.13 дахь заалт)
- Цар тахлын тухай хууль (13.3 болон 14.2 дэх заалт)

Эдгээр хуулиудтай холбоотойгоор улс төрийн намууд, нэр дэвшигчид болон бусад иргэдээс хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хандаж хичнээн гомдлыг холбогдох эрх бүхий байгууллагуудад гаргасан бэ? Тэдгээрийн хичнээн нь нэр төр гутаах, алдар хүндэд халдсан болон худал мэдээлэл тараасан гэх агуулгаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдсон байна вэ?

Сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн мэдээлэл, сурталчилгаатай холбоотой

өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүргийг Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо хүлээн авч шийдвэрлэхээр зохицуулсан. Иймд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдох хэргийн мониторингийн анхдагч мэдээллийг дараах байдлаар бүрдүүлээ. Үүнд:

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу дээр нэр дурдсан эрх бүхий байгууллагуудад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоотой өргөдөл гомдлын талаарх мэдээлэл авах хүсэлтийг илгээж, хуулийн хугацаанд хариу тайлбаруудыг хүлээн авсан.
- Сонгуулийн үед редакцууд эрх бүхий байгууллагад дуудагдаж шалгагдсан эсэх талаарх мэдээллийг бүрдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн 32 байгууллагад албан хүсэлт бүхий судалгааны асуулгыг илгээснээс 10 байгууллагаас хариу хүлээн авав.
- Мониторингийн хугацаанд shuukh.mn сайтыг ашиглаж, шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийг нягтлан шалгалаа.

Дээр нэр дурдсан хуулиудын сонгуулийн үеийн хэрэгжилтэд мониторинг хийж, эдгээр нь хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нийцэж буй талаар дүгнэлт хийхийг зорьсон юм.

2) Сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хугацааны телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрийн агуулгын мониторинг

Телевизийн мэдээллийн хөтөлбөрт дараах шалгуур үзүүлэлтийн дагуу тоон болон чанарын мэдээлэл бүрдүүлэв. Үүнд:

- Телевизүүд УИХ-ын 2020 оны сонгуульд оролцогч улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн тухай мэдээллийг хэр хэмжээнд (давтамж, хугацаа), ямар сэдэв, агуулгын хүрээнд сонгогчдод хүргэв.

- Сонгуулийн сурталчилгааны кампанит ажлын хугацаанд телевизүүд мэдээллийн хөтөлбөрөөрөө дамжуулан сэтгүүл зүйн үүргээ хэр түвшинд биелүүлэв.
- Телевизийн мэдээллийн хөтөлбөрийн бүтцийг задалж харвал сонгуулийн төлбөртэй сурталчилгаа, далд сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл ямар харьцаатай байв?
- Телевизүүд мэдээллийн хөтөлбөртөө сэтгүүл зүйн мэргэжлийн стандарт, хэм хэмжээг хэрхэн мөрдөж ажиллав? Тухайлбал, мэдээллийн хөтөлбөрөөрөө дамжуулан тархи угаах, мушгин гуйвуулах, суртал ухуулга хийх зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйд харш үйлдэл гаргасан уу?
- Телевизийн редакцууд мэдээллийн хөтөлбөртөө хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг хэр мөрдөж ажилласан бэ? Тодруулбал, нягталж шалгаагүй худал мэдээлэл, тэнцвэргүй мэдээлэл, ялгаварлан гадуурхах, буруутгагдсан этгээдээс тайлбар аваагүй, залруулга гаргаагүй, гүтгэлэг доромжлол агуулсан, далд болон төлбөртэй сурталчилгааг ялгаж таниулаагүй гэх мэт
- Телевизүүд үзэн ядах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үг хэллэгийг мэдээллийн хөтөлбөртөө агуулсан уу?

Мониторингийг хийхдээ дараах алхамуудыг мөрдөж ажиллав. Тодруулбал:

1. Үйл ажиллагаа явуулсан хугацаа, үзэгчдийн хүртээмжээрээ эхний 10-т багтах өргөн нэвтрүүлгийн телевизүүдээс MYONT, ТВ9, UBS, MN25, NTV телевизүүдийг сонгож авлаа.
2. Сонгуулийн сурталчилгааны кампанит ажлын 21 хоногийн оргил цагийн буюу 19:00-21:00 цагийн мэдээллийн хөтөлбөрүүдийг түүвэрлэн авсан.
3. Тоон болон чанарын мэдээлэл цуглуулах шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, судлаачдын багаар хэлэлцүүлэв.
4. Шалгуур үзүүлэлтийн дагуу анхдагч мэдээлэл цуглуулах хүснэгтийг бэлдэж судлаачдад

танилцуулж сорилын судалгаа хийж, аргачлалыг сайжруулж ажилласан.

5. Судлаачид хариуцсан телевизийнхээ мэдээллийн хөтөлбөрийн агуулгыг нэг бүрчлэн үзэж шалгуур үзүүлэлтийн дагуу тэмдэглэл хөтлөн анхдагч мэдээллийг бүрдүүлэв.
6. Бүрдүүлсэн анхдагч мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлан бэлтгэв.

Хоёр. УИХ-ын сонгуулийн жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлт

I. Ерөнхий мэдээлэл

Сонгуулийн тухай хуулийн 3.1.4-т “сонгуулийн жил” гэж дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгоно гэж заасан. Улсын Их Хурлын 2020.01.30-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө эхлэхээр товлон зарласан бөгөөд Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байхаар тогтоосон.

Улсын Их Хурлын 2020.06.30-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай” 1 дүгээр тогтоолд 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон нэр бүхий гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн.

Иймд энэхүү тайланд 2020.01.01-ний өдрөөс эхлэн 2020.06.30-ны өдрийг хүртэлх болон давж заалдах хугацааг оруулан 2020.09.01-ний өдрийг хүртэлх хугацаанд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдох хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Энэ хүрээнд гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага болон хэвлэл мэдээллийн редакцуудаас холбогдох тоон мэдээллийг авч, шинжлэв.

II. Хэргийн шийдвэрлэлт

2.1. “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийн шийдвэрлэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т зааснаар тагнуулын байгууллага Эрүүгийн хуулийн 14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/, 14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/, 14.7 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/, 14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, 14.9 /Сонгуулийг хууль бусаар

явуулах хуйвалдаан зохион байгуулах/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна. Үүнээс 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зохицуулалт нь сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарласан шинжтэй байна. Тодруулбал, тус зүйлийн 1-т “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасан бөгөөд “илт худал мэдээлэл” гэдгийг тус хуульд тодорхойлоогүй.

Эрүүгийн хуулийн хатуу хариуцлагыг хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэлийн эрх чөлөөний тухай асуудал дээр зөвхөн “онц их буруутай” тохиолдолд ашигладаг. Өөрөөр хэлбэл, мэдээлэл тараагч нь хүний үндсэн эрх, нэр төрийг санаатайгаар (өөрөөр хэлбэл мэдсээр байж) буруугаар ашиглах нь “онц их буруутай байх” гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хууль нь худал хуурмаг, нэр төрд халдсан баримтыг тухайн мэдээллийг тараагч нь худал болохыг нь мэдэлгүйгээр олон нийтэд түгээхэд ч эрүүгийн шийтгэл хүлээх эрсдлийг агуулж байгаа юм. Үнэн зөв, баталгаатай хэмээн эх сурвалждаа найдаснаас, түүнчлэн баримтыг нөхцөл байдлын улмаас гүйцэд нягтлаагүйн улмаас баримт/мэдээлэл нь буруу болохыг нийтийн хүртээл болсоны дараа олж мэдэх явдал сэтгүүл зүйд тохиолддог. Иймд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь сэтгүүлчийн мэргэжлийн ажлаа гүйцэтгэхдээ гаргасан санамсаргүй алдаа нь эрүүгийн хариуцлага хүлээх шалтгаан болох ёсгүй хэмээн үздэг хэмээн ХМЗ-өөс Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан өгсөн тайлбарт дурджээ.¹

Тагнуулын байгууллага Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үеэр хүний улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шинжтэй нийт 201 гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь улс төрийн

¹ Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс УИХ-ын гишүүн Б.Энхбаярт хүргүүлсэн 2020.09.25-ний өдрийн 01/152 тоот албан бичиг

нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдсан илт худал мэдээлэл тараасан гэх 23 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнийг хуулийн дагуу шалгаж, прокурорын байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн байна.²

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 1-т зааснаар мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч хянаж үзсэн даруй, эсхүл энэ хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж дараах шийдвэрийн аль нэгийг гаргасан даруй энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ: 1/ хэрэг бүртгэлтийн хэрэг нээх; 2/ хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргах; 3/ харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах.

Тагнуулын байгууллагын хувьд дээр дурдсан 23 гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагаа явуулсны дараа бүгдэд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн эсэх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргасан эсэх, харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргасан эсэх талаар тодорхой дурдаагүй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийн 1-т “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллаж байна” гэсний дагуу дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй гэжээ.³

Мөн энд дурдсан 23 хэргийн цаана хэчнээн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан хамаарч байгаа талаар дурдаагүй байна. Тагнуулын Ерөнхий Газраас ХМЗ-д ирүүлсэн 2020.08.31-ний 1145 тоот албан бичигт дурдсанаар “Бүртгэгдсэн гомдол, мэдээлэлд дүгнэлт хийхэд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагууд нь авагдсан мэдээ, мэдээллийнхээ үнэн бодит эсэхийг нягталж, шалгахгүйгээр нийтэд мэдээлсний улмаас бусдын нэр хүндэд халдах гэмт хэрэгт холбогдон шалгагджээ” хэмээн тэмдэглэсэн байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn-д 2020.10.10-ны өдрийн байдлаар 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлээгүй байна.

² Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн Тагнуулын ерөнхий газрын 2020.08.31-ний өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 1145 тоот албан бичиг

³ Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын 2020.09.16-ны өдрийн 16/1069 тоот албан бичиг

2.2. “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн шийдвэрлэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн 13.14 /Худал мэдээлэл тараах/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна. Энэ гэмт хэргийн зохицуулалт нь сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарласан шинжтэй байна.

Тодруулбал, 13.14 дүгээр зүйлд зааснаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэх бөгөөд “илт худал мэдээлэл” гэдгийг тус хуульд мөн тодорхойлоогүй.

ЮНЕСКО-гоос боловсруулсан “Худал мэдээ болон хуурамч мэдээлэл Сэтгүүл зүйн боловсрол сургалтын гарын авлага”-таа хуурамч мэдээлэл (fake information) гэдгийг дараах гурван төрлөөр ангилсан байдаг.

- Худал /хуурамч/ мэдээлэл (Disinformation) гэдэг нь хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага, улс оронд хор хохирол учруулахын тулд урьдчилан төлөвлөж зохиосон худал мэдээлэл
- Хуудуутай мэдээлэл (Misinformation) гэдэг нь худал мэдээлэл боловч хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага, улс оронд хор хохирол учруулах санаа зорилго агуулаагүй, зохиогоогүй мэдээлэл
- Дэгс мэдээлэл (Mal-information) гэдэг нь бодит байдалд үндэслэсэн боловч хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллага, эсвэл улс оронд хор хохирол учруулахын тулд ашигласан мэдээлэл

2020.01.10-2020.09.01-ний өдрийн хугацаанд цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй холбоотой “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн шинжтэй

24 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд үүнээс 20-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт хүргүүлсэн, 4-ийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.⁴ Энэ гэмт хэргээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг шийтгэх саналыг цагдаагийн байгууллага буюу мөрдөгч гаргаагүй байна.

2.3. “Сонгуулийн хуулийг зөрчих” зөрчлийн шийдвэрлэлт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-т зааснаар цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1, 13, 15 дахь хэсэгт заасан зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Тодруулбал, 17.1 дүгээр зүйлийн 1-т зааснаар “Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, 13-т зааснаар “Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, 15-д зааснаар “Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.

2020.01.10-2020.09.01-ний өдрийн хугацаанд цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй холбоотой “Сонгуулийн хуулийг зөрчих” зөрчлийн шинжтэй 19 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд дараах байдлаар шийдвэрлэсэн байна.⁵

⁴ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2020.09.17-ны өдрийн 86/2731 тоот албан бичиг

⁵ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2020.09.17-ны өдрийн 86/2731 тоот албан бичиг


Хүснэгт 1. Сонгуулийн хуулийг зөрчих зөрчлийн хэргийн шийдвэрлэлт**2020 оны эхний 9 сарын байдлаар**

№	Зөрчлийг шийдвэрлэсэн байдал	Тоо	Эзлэх хувь
0	ХҮЛЭЭН АВСАН НИЙТ ГОМДЛЫН ТОО	19	100%
	Үүнээс:		
1	Зөрчлийн хэрэг нээж шалгасан	3	15.7%
2	Хялбаршуулсан журмаар торгож шийдвэрлэсэн	1	5.4%
3	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзах санал хүргүүлсэн	15	78.9%

Дээрх хүснэгтээс харахад, сонгуулийн хуулийг зөрчих 1 зөрчилд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд шийтгэл оноосон бол 15 зөрчлийн хэргийг нээхээс татгалзах санал гаргасан байна.


2.4. Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар ХХЗХ нь 46 дугаар 46.13, 46.19, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.3, 47.3 дахь заалтуудад хяналт тавихаас гадна Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журмын 3-р зүйлийн 3.1, 2 дугаар зүйлийн 2.2, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт хяналт тавих чиг үүрэгтэй байна. График 1-ээс харна уу.

График 1. ХХЗХ-нд эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн санал дүгнэлт

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн хугацаанд эрх бүхий байгууллагууд болох Цагдаагийн байгууллагаас 224, ШӨХТГ-аас 67, Тагнуулын байгууллагаас 19, бусад газраас 15, нийт **325** санал, дүгнэлт ирүүлсний дагуу холбогдох үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, цахим орчны үйлчилгээ эрхлэгчид хүргүүлж ажилласан бөгөөд **138** санал, дүгнэлтэд холбогдох арга хэмжээг авсан байна.⁶

График 2. ХХЗХ-ноос эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн санал дүгнэлтэд холбогдох арга хэмжээ авсан эсэх /эзлэх хувиар



Дээрх графикаас харахад, ХХЗХ нийт 325 санал дүгнэлтийг эрх бүхий байгууллагуудаас хүлээн авсан бол 138 (42.4%) -т хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээ авсан 187 (57.6%) -т нь хуулийн ямар нэгэн арга хэмжээ авалгүйгээр шийдвэрлэжээ.

2.5. Прокурорын хяналт тавьсан хэргийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллага нь хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрхтэй. Улсын Ерөнхий Прокурорын газраас Монголын хэвлэлийн зөвлөлд 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

⁶ ХХЗХ-ны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын 2020.10.09-ний өдрийн 04/1767 тоот албан бичиг

ирүүлсэн 2/5569 тоот албан бичигтээ, 2020 он гарснаар есдүгээр сарын нэгний өдрийн байдлаар иргэд, төрийн байгууллагаас гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй холбоотой хэрэгт дараах хяналтыг тавьсан байна. Тодруулбал, Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо 492 байгаагаас хохирол, гомдол гаргагчийн тоо 480 байна.

Дараах төрлийн гэмт хэргүүдэд хэрэг бүртгэлийн хэрэг нээснээс Эрүүгийн хуулийн 13.14 Худал мэдээлэл тараах зүйлээр 193, Эрүүгийн хуулийн 14.2, 14.3 Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах, Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах зүйл ангиар тус бүр 0, Эрүүгийн хуулийн 14.8.1 Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэгт 13, нийт 206 хэрэгт холбогдсон хүний 149 байна. Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны тоо 18 байна.

Хэрэг бүртгэлийн шийдвэрлэлтийн тухайд хэрэг бүртгэлийн хэрэг хаасан 80, одоо ажиллагаанд байгаа 118, шүүхэд шилжүүлсэн 8 хэрэг байна. Үүнээс шийтгүүлсэн хүний тоо 8, сэтгүүлч хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны тоо 0, давж заалдах хяналтын шатны шүүхийн шийдвэрлэлт мөн 0 байгаа тухай дурджээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 20-ны батлагдсанаар Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт шинээр Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчлийг оруулсан. Зөрчлийн тухай хуулиар 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн” зөрчлөөр 1 гомдол, мэдээлэл ирсэн.

17.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан” зөрчлөөр 507 гомдол, мэдээлэл ирснээс хэргийн тоо 59, гомдлыг хүлээн авахаас татгалзсан 18 байна. Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны тоо 18 байна.

17.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг “Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа

явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй” зөрчлөөр 1 гомдол, мэдээлэл иржээ.

17.1 дүгээр зүйлийн 15 дахь хэсэг “Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн” зөрчлөөр 5 гомдол, мэдээлэл ирснээс хэргийн тоо 2 байна.

17.1 дүгээр зүйлийн 16.7 дахь заалт харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан зөрчлөөр 57 гомдол, мэдээлэл ирснээс хэргийн тоо 10, үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны тоо 1, гомдлыг хүлээн авахаас татгалзсан 1 зөрчлийн хэрэг байна.

17.1 дүгээр зүйлийн 19 дэх хэсэгт Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан зөрчлөөр 1 гомдол, мэдээлэл тус тус 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс есдүгээр сарын 1-ний хооронд Прокурорын байгууллагад ирж хяналт тавигджээ.

2.6. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд

Өмнөх хэсгүүдэд дурдсанаар, мониторингийн хугацаанд Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан шийтгэгдээгүй тухай ирүүлжээ. Гэвч хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг сэтгүүлчийг цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбогдуулан төрийн өндөр албан тушаалтан гомдол гаргаснаар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 500.000 төгрөгөөр торгох ял оногдуулсан.

Явцын буюу хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шат буюу шүүхийн өмнөх шатан дахь

шийдвэртэй холбоотойгоор хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд цаг хугацаа, хөрөнгө, алдар хүндээрээ хохирох явдал бийг зарим жишээнээс харж болохоор байна. Тодруулбал, “Ворд Медиа” ХХК-ийн хувьд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг давж заалдахад дунджаар өмгөөллийн хөлсөнд 1,000,000 сая төгрөг, шүүх хуралд оролцохын тулд гурван ажилтан 2-3 өдрийг зарцуулжээ.⁷

Энэ жишгээр тооцож үзэхэд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн жилд Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” 23 хэрэг, 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” 20 хэрэг, “Сонгуулийн хуулийг зөрчих” 19 зөрчилд өөрсдийгөө хууль зүйн арга хэрэгслээр хамгаалахтай холбоотойгоор 62,000,000 /жаран хоёр сая/ төгрөгийн зардал гаргасан гэж үзэж болохоор байна. /Энэхүү тоо нь үүгээр хязгаарлагдахгүй юм./

Түүнчлэн 2020 оны хоёрдугаар сард өрөг.мн (urug.mn) сайтын **Баримт: Эрдэнэт үйлдвэрийн мөнгө ёолдоггүй ба дураараа дургигчид** нэртэй эрэн сурвалжлах нэвтрүүлэг бэлтгэн цацсаны улмаас “Сод Монгол” групп ХХК-аас Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шүүхэд гомдол гаргаж, өрөг.мн сайтаас 1 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн байна. Мөн тус сайтыг ХМЗ-ийн Гомдол хүлээн авах, барагдуулах журмын дагуу Ёс зүйн зарчмын 5 дахь заалт “Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана” гэснийг зөрчсөн хэмээн гомдол гаргасныг Хороо дөрөвдүгээр сард нягталж хэлэлцээд Ёс зүйн зарчим зөрчөөгүй хэмээн шийдвэрлэжээ.

“Шуурхай эрэн сурвалжлах залуучууд” ТББ-ын дэргэдэх эрэнньос.мн (erennews.mn) сайтыг 2020 оны 6 дугаар сард хоёр удаагийн хэргээр цагдаагийн байгууллага дуудан шалгасан боловч эдгээр нь хэрэгсэхгүй болсон. Тодруулбал, Дархан-Уул аймагт МАН-аас нэр дэвшигч Г.Дамдинням тус сайтаас түүнийг сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаа болоогүй байхад сурталчилгаагаа эхлүүлсэн байна хэмээн бичсэнд цагдаагийн байгууллагад гомдол гаргасан

⁷ “Ворд медиа” ХХК-иас Хэвлэл мэдээллийн зөвлөлд 2020 оны 9 дүгээр сард ирүүлсэн албан бичиг

боловч хэрэг үүсгэх боломжгүй хэмээн шийдвэрлэсэн. Мөн УИХ-ын гишүүн Х.Нямбаатар тус сайтыг 6 дугаар сарын нэгэн нийтлэлдээ нэр төрд халдаж гүтгэсэн хэмээн үзэж гомдол гаргасан боловч эрх бүхий байгууллагаас хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

Зариг.мн сайтыг 2019 оноос 2020 оны дөрөвдүгээр сарын байдлаар Цагдаагийн байгууллагаас 12 удаа дуудан байцаасан тохиолдол бүртгэгдэв.⁸ Гомдол гаргасан иргэдийн дийлэнх нь төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн албан хаагч байгаа юм. Тус сайтаас ХМЗ-д ирүүлсэн мэдээллээс харахад гомдол гаргагчид нь УИХ-ын гишүүн асан Ц.Гарамжав, Ж.Энхбаяр, Э.Эрдэнэбат, Хөдөө аж ахуйн дэд сайд асан Ж.Сауле, ТЕГ-ын дарга Д.Гэрэл нар нэр төрд халдсан хэргээр цагдаагийн байгууллагад гомдол гаргасан байна.

III. “Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах”, “худал мэдээлэл тараах” асуудлыг Хэвлэл мэдээллийн зөвлөл шийдвэрлэх нөхцөл

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг баталсан. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2019 оны 5 дугаар сард Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд сонгуулийн санал хураалт эхлэхийн өмнө сурталчилгаа дуусахаас өмнө гарсан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт хийж байгаа талаар танилцуулсан.⁹ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэж заасан бөгөөд 2019 онд нэмсэн 10 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” хэмээн заасан.¹⁰

Энэ нь сонгуулийн жилд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага “худал мэдээлэл тараах”, “сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг Хэвлэл мэдээллийн зөвлөл бие даан шийдвэрлэх тохиромжтой механизм болохыг харуулж байна.

⁸ <https://www.gic.mn/post/r/1514>

⁹ “Хэвлэлийн зөвлөл: Ёс зүйн зарчимд шинэ заалт нэмэгдлээ”. 2019.05.02 <https://news.zindaa.mn/2ps3>

¹⁰ Хэвлэл мэдээллийн зөвлөл. Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг. Улаанбаатар, 2020 он. 18 дахь тал

Тохиолдол 1. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг шийдвэрлэсэн нь

Хөдөлмөрийн Үндэсний намаас /ХҮН/ Tovch.mn сайтад хаяглан гомдол ирүүлснийг энэ өдөр хэлэлцлээ. Тус сайтын пэйж хуудсаар 2020 оны есдүгээр сарын 5-ны өдөр шууд дамжуулсан “Т.Доржхандыг “ХҮН”-ыг ганц хүний нам буюу компанийн нам болгох гэж байна” хэмээн намын гишүүд нь үзэж байна. Иймд “Нийслэлийн намын хорооны дарга П.Наранбаярыг дүрмийн бусаар сонгосон гэж үзэж тус намын Нийслэлийн бүх гишүүд хуралдаж байна” гэх агуулга бүхий мэдээллийг бэлтгэхдээ тус намд 2018 он хүртэл гишүүн байсан, одоо гишүүнчлэлгүй, холбоо хамааралгүй бүлэг этгээд намын нэр, таних тэмдгийг зөвшөөрөлгүйгээр ашиглан улс төрийн үзэл бодлоо илэрхийлснийг нягтлалгүй олон нийтэд нэг талын баримттай, ор үндэслэлгүй, буруу ташаа, хуурамч мэдээллийг шууд дамжуулсан нь Ёс зүйн зарчмаа зөрчсөн эсэхийг тодруулж өгөхийг ХҮН хүссэн. Сайтын зүгээс ХМЗ-д хариу тайлбар ирүүлсэн бөгөөд уг тайлбартаа тухайн өдөр болж байсан үйл явдлыг газар дээрээс нь шууд дамжуулсан, уг арга хэмжээнд оролцож байгаа хүмүүс гишүүнчлэлгүй болсон, намын нэр, таних тэмдгийг зөвшөөрөлгүй ашигласан эсэхтэй холбоотой гомдол нь манай сайтад хамааралгүй гэж үзэж байна гэжээ. Мөн ийм үйл явдал болж байна гэдгийг л шууд дамжуулсан, ямар нэг эвлүүлэг, урьдчилж бэлдсэн зүйл байхгүй, уг арга хэмжээг зохион байгуулахад сайтын зүгээс ямар ч оролцоо байхгүй, зөвхөн мэдээлэл дамжуулах ажлаа хийсэн тул ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгээ илэрхийлжээ. Түүнчлэн тухайн арга хэмжээнд олонд танигдсан ХҮН-ын үүсгэн байгуулагчид байсан, бусад ирсэн гишүүдийг Нийслэлийн намын хорооны гишүүн эсэхийг нэг бүрчлэн шалгаж тогтоох эрх болон тийм боломж сэтгүүлчид байхгүй гэсэн байна.

Радио, телевизийн Ёс зүйн хороо энэхүү гомдлыг хэлэлцээд шууд дамжуулалтын үеэр оролцогчийн яриаг үнэнд нийцсэн эсэхийг нягталж шалгах боломжгүй, болж

буй үйл явдлыг шууд дамжуулсан, редакцын зүгээс ямар нэг нэмэлт үйл ажиллагаа явуулаагүй, редакц уг үйл явдалтай ямар ч хамааралгүй гэж үзлээ. Түүнчлэн редакц олон нийтэд мэдээлэл дамжуулах үүргийнхээ хүрээнд үйл явдлыг дамжуулсан гэдгээ илэрхийлсэн, мөн уг мэдээллийг төлбөртэйгээр цацсан гэх нотолгоо байхгүй, болж буй үйл явдлын талаар шууд дамжуулж байгааг далд сурталчилгаа явуулсан гэж батлах боломжгүй тул tovch.mn сайт нь ёс зүйн алдаа гаргаагүй гэж дүгнэлээ. <https://medi-acouncil.portal4.sodonsolution.org/a/183>

Тохиолдол 2. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэхийг шийдвэрлэсэн нь

ТВ4 телевизээр 2020 оны нэгдүгээр сарын 22-ны өдөр “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь “хөлдөөгөөд” 4 жил болж байна гэв” мэдээ цацагдсан бөгөөд ТВ4 телевиз энэ мэдээг гаргахдаа нэр төрд халдсан, ташаа мэдээллийг нягтлаагүй, буруутгагдсан талаас тайлбар аваагүй гэсэн гомдлыг нэгэн иргэн ирүүлжээ.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төвийн халаалтын систем доголдож, сумын төвийн барилгууд бүгд хөлдсөн байна. Сургууль, цэцэрлэг, орон сууц гээд бүгд хөлдсөн бөгөөд тухайн үед хөлдсөн 64 айлын орон сууц түүнээс хойш халаалтгүй байгаа ажээ. Байрны оршин суугчид өнөөг хүртэл сум, аймаг, Засгийн газар, Ерөнхийлөгч гээд төрийн бүхий л шатны байгууллагад хандаад амжилт олохгүй байгаа талаар сумын хоёр иргэн ярилаа. Хоёр иргэн сумын төвийн халаалтыг хариуцдаг төвийг одоогийн Засаг дарга нь хувьчилж авсныг энэ хооронд мэдэж авсан тухайгаа сэтгүүлчид ярьжээ.

Гэхдээ энэ яриа үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулах өөр түвшний эх сурвалж ашиглаагүй, тэдний гартаа барьсан бичиг баримтууд нь болсон явдлыг нотолж буй эсэхийг үзэгчдэд тодорхой харуулаагүй нь мэдээллийг үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулаагүй. Мөн мэдээний дундуур Засаг даргын гэр бүлийн гэрэл зургийг

үзүүлэхдээ гэр бүлийн гишүүдээс зөвшөөрөл аваагүй тул энэ мэдээлэл нь Ёс зүйн зарчмын 1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ” гэснийг, мөн 2.3-т заасан “Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна”, 6-д заасан “Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана”, 6.2-т заасан “Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно” гэснийг тус тус зөрчсөн гэж Радио, телевизийн ёс зүйн Хороо үзлээ. <https://mediacouncil.portal4.sodonsolution.org/a/159>

IV. Хэсгийн дүгнэлт зөвлөмж

- Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлийн зохицуулалт нь сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндийг, 13.14 дүгээр зүйлийн зохицуулалт нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг тус тус хамгаалах зорилготой байх бөгөөд Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд энэ зорилго бий. Тодруулбал, Иргэний хуулийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ”, 21.3-т “Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан. Мониторингийн хугацаанд эрх бүхий байгууллагад хандсан дийлэнх олонход нь хэрэг үүсгэхээс татгалзсан бол цагдаагийн байгууллага 1 зөрчилд торгох шийтгэл оногдуулсан байна.

- Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 14.8, 13.14 дүгээр зүйлийн дагуу гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх үйл явц нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлэг, сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжтэй цензур бий болгож байна. Улмаар энэ нь “дуугүй байх” гэсэн өөрийн цензурт түлхэх эрсдэлтэй.

- Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” нь Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл, 13.14 дүгээр зүйлд заасан хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах адил зорилготой байна. Энэ хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сонгуулийн жилд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага “худал мэдээлэл тараах”, “сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх үр нөлөөтэй бүтэц болох нь гомдол шийдвэрлэлтийн байдлаас харагдаж байна.

Гурав. Телевизүүд сонгуулийн хугацаанд сэтгүүл зүйн үүргээ биелүүлсэн үү?


I. Ерөнхий мэдээлэл

Энэхүү мониторингийг УИХ-ын сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хугацаанд буюу 2020 оны 6 дугаар сарын 2-ноос 22-ны өдрийг хүртэлх нийт 21 өдрийн мэдээллийн хөтөлбөрийг хамруулан хийлээ. Ингэхдээ өргөн нэвтрүүлгийн телевизүүд буюу хүртээмж болон үзэгчдийн тоогоороо тэргүүлэгч 5 телевизийн оргил цагийн (19:00-21:00 хүртэлх) мэдээллийн хөтөлбөрүүдийг сонгон хамруулсан. Үүнд: МҮОНТ, NTV, ТВ9, MN25, UBS гэсэн таван телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд багтсан болно.

II. Сонгуулийн сурталчилгааны үеэр өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт хийсэн мониторингийн дүн

Мониторингт хамрагдсан өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуулийн сэдэвтэй хамаарах нийт **1324** мэдээ, мэдээлэл бүртгэгдэв. Эдгээр мэдээллийн давтамжийг цацагдсан огноогоор нь ангилбал сонгуулийн сурталчилгааны гуравдахь долоо хоногт хамгийн олон мэдээ, мэдээлэл цацагдсан байна.

График 1. Мэдээллийн давтамж / сурталчилгааны хоногоор



Сонгуулийн сурталчилгааны 21 хоногийн (6 дугаар сарын 02-ноос 22-ны өдөр хүртэлх) хугацаанд нэр бүхий таван телевизээр нийт **378,000 секунд буюу 6,300 минутын** мэдээллийн хөтөлбөр цацагджээ. Өөрөөр хэлбэл нэг телевизийн сувгаар өдөрт дунджаар **60 минут буюу 1**


цагийн мэдээллийн хөтөлбөр гарсан байна.

Мэдээллийн хөтөлбөр нь ихэвчлэн цаг үеийн шинжтэй үйл явдлын мэдээ, сонгууль 2020, сурвалжилга, зочны ярилцлага, гадаад мэдээ, спортын мэдээ, цаг агаарын мэдээ, зар сурталчилгаа гэсэн бүтэцтэй байна. Үүнээс **176,120 секунд буюу 2,935 минут** нь сонгуультай холбоотой мэдээлэл байв. Өөрөөр хэлбэл, сонгуулийн сурталчилгааны үеэр мэдээллийн хөтөлбөрийн **47%** нь (мэдээллийн хөтөлбөрийн нийт үргэлжлэх хугацаанаас тооцов) сонгуультай холбоотой мэдээ, мэдээлэл эзэлж байна.

Мониторингийн аргачлалын дагуу судалгааны хамрах хүрээг телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт цацагдсан мэдээ мэдээллээс зөвхөн “Сонгууль” гэсэн сэдэвтэй хамаарахыг түүвэрлэн авч, эдгээрийг шалгуур үзүүлэлтийн дагуу нягтлан ангилсан болно.

График 2-оос харахад сонгуультай холбоотой мэдээ, сурвалжилгыг **ТВ9** болон **МҮОНТ** бусдаасаа илүү олон давтамжтайгаар нэвтрүүлсэн байна.


График 2. Сонгуультай холбоотой мэдээллийн давтамж / ТВ тус бүрээр харьцуулснаар / давтамжаар



Мөн мониторингийн зорилгын хүрээнд телевизүүдээр цацагдаж олон нийтэд хүрсэн сонгуультай холбоотой мэдээллийг төрлөөр ангилан харуулсан бөгөөд нийт мэдээллийн 85 хувь нь “төлбөртэй мэдээлэл” байв. Үүнд: ихэвчлэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн штабаас бэлтгэн боловсруулсан (сэтгүүл зүйн ямар нэгэн үйл ажиллагаа ороогүй) нэр дэвшигчийн танилцуулга, бүтээсэн түүх намтар, нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, сонгогчдыг дэмжихийг уриалсан, мэдээлэл түгээгч

өөрийгөө магтаж сайшаасан эерэг мэдээлэл, эсвэл өрсөлдөгчөө муулсан сөрөг агуулга бүхий нөлөөллийн мэдээлэл, сурталчилгаа багтаж байв.

График 3. Сонгуультай холбоотой мэдээллийн төрөл /нийт хугацаанд



Телевизүүдээр цацагдсан сонгуультай холбоотой мэдээллийг зарцуулсан хугацаагаар ангилж харвал, мониторингт хамрагдсан телевизүүд 21 өдрийн мэдээллийн хөтөлбөрийнхөө 48.8 цагийг "сонгууль"-д зориулсан бөгөөд үүнээс 38.3 цагийг төлбөртэй сурталчилгаанд, 4.9 цагийг далд сурталчилгаанд, 5.6 цагийг редакц өөрсдөө ажилласан сонгогчдын боловсрол, мэдлэгт зориулсан мэдээ эзэлж байна.

Хүснэгт 1. Сонгуультай холбоотой мэдээллийн төрөл / үргэлжилсэн хугацаагаар

Мэдээллийн төрөл	Үргэлжилсэн хугацаа		
	Секундээр	Минутаар	Цагаар
Төлбөртэй мэдээ	137,880.00	2,298.00	38,3
Далд сурталчилгаа	17,800.00	296.67	4,9
Сонгогчийн боловсролд чиглэсэн мэдээлэл (Мэдээ, тодруулга ярилцлага, бусад мэдээлэл)	20,440.00	340.67	5,6
Нийт	176,120.00	2,935.33	48,8

Бусад мэдээлэл гэдэгт сонгогчдын боловсролд зориулсан зөвлөмж, заавар гэх мэт

Хүснэгт 1-ээс харахад сонгуулийн кампанит ажлын үед телевизийн мэдээллийн хөтөлбөрт мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагаа 10 хүрэхгүй хувьд байж үлдсэн 90 хувьд нь ил болон далд сурталчилгааны мэдээлэл олон нийтэд хүрчээ.

Хүснэгт 2. Сонгуулийн талаарх мэдээллийн агуулга

Мэдээллийн агуулга	Давтамж (тоогоор)	Эзлэх хувь
Нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа, нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, тойргийн үйл явдлын тухай мэдээлэл	1,120	84.6%
Сонгогчийн боловсролд зориулсан цаг үеийн мэдээ, тодруулга ярилцлага	98	7.4%
Засгийн газар болон түүний харьяа яам, агентлагууд (ЭМЯ, ГХЯ, УОК)-ын үйл ажиллагаа болон Ерөнхий сайд, эрх баригч намын үйл ажиллагааны тухай (магтсан, сайшаасан, дэмжсэн)	66	5.0%
Засгийн газрын үйл ажиллагаа, эрх баригч намыг шүүмжилсэн	19	1.4%
Хотын захирагч болон НЗДТГ-тай холбоотой цаг үеийн шинжтэй үйл явдлын мэдээлэл (магтсан, сайшаасан, дэмжсэн)	17	1.3%
УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн шүүх хуралтай холбоотой цаг үеийн мэдээлэл	4	0.3%
Нийт	1,324	100%

Сонгуулийн кампанит ажлын үед мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгогчдыг ардчилсан сонголтоо хийхэд нь туслах олон талт тэнцвэртэй, хараат бус мэдээллээр хангах үүргийг хүлээдэг. Тэгвэл Монголын телевизүүд мэдээллийн хөтөлбөртөө нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа, нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, тойргийн үйл явдлын тухай мэдээлэл зэрэг редакцын оролцоогүй бэлэн буюу төлбөртэй мэдээлэлд **84,6** хувийг зориулжээ.

Үүний зэрэгцээ КОВИД-19 цар тахлын дэглэмтэй холбоотой МУ-ын Засгийн газар болон түүний харьяа яам, агентлагуудаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаарх магтсан, сайшаасан, дэмжсэн эерэг агуулга бүхий далд сурталчилгаанд мэдээллийн хөтөлбөрийнхөө **5** хувийг зориулсан байна.

Харин **7,4** хувьд нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ мэдээлэл байна хэмээн бүртгэгдсэнээс харахад сонгуулийн сурталчилгааны хугацаанд телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрийн ойролцоогоор аравны нэг нь редакцын бодлогын хүрээнд сэтгүүл зүйн үүргээ биелүүлжээ.

Хүснэгт 3. Сонгуулийн талаарх мэдээллийн агуулга/ТВ тус бүрээр харьцуулбал

Мэдээллийн агуулга	МҮОНТ	NTV	ТВ9	MN25	UBS	Нийт
Нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа, нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, тойргийн үйл явдлын тухай мэдээлэл	18.8%	21.3%	24.8%	18.9%	16.2%	100.0%
Засгийн газар болон түүний харьяа яам, агентлагууд (ЭМЯ, ГХЯ, УОК)-ын үйл ажиллагаа болон ерөнхий сайд, эрх баригч намын үйл ажиллагааны тухай <i>(магтсан, сайшаасан, дэмжсэн)</i>	50.0%	0.0%	10.6%	21.2%	18.2%	100.0%
Хотын захирагч болон НЗДТГ-тай холбоотой цаг үеийн шинжтэй үйл явдлын мэдээлэл <i>(магтсан, сайшаасан, дэмжсэн)</i>	23.5%	0.0%	0.0%	41.2%	35.3%	100.0%
Засгийн газрын үйл ажиллагаа, эрх баригч намыг шүүмжилсэн.	0.0%	0.0%	78.9%	21.1%	0.0%	100.0%
Сонгогчийн боловсролд зориулсан цаг үеийн мэдээ, тодруулга ярилцлага, шторк	34.7%	23.5%	16.3%	17.3%	8.2%	100.0%
УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн шүүх хуралтай холбоотой цаг үеийн мэдээлэл	50.0%	0.0%	0.0%	25.0%	25.0%	100.0%

Нэр дэвшигчдийн сонгуулийн төлбөртэй сурталчилгааг телевизүүд мэдээллийн хөтөлбөрийнхөө дунджаар тавны нэгд нь нэвтрүүлсэн бөгөөд ТВ9, NTV телевизүүд бусдаасаа 2-6 хувиар илүү нэвтрүүлсэн байна. Сонгуулийн сурталчилгааны хугацаанд МУ-ын Засгийн газар болон түүний харьяа яам, агентлагуудын үйл ажиллагаа, Ерөнхий сайд болон эрх баригч намын хэрэгжүүлж буй ажлуудыг дэмжин магтаж сайшаасан нэг талын тэнцвэргүй мэдээллийн тал нь (50%) МҮОНТ-ээр цацагдсан бол ТВ9 телевиз эрх баригч намын, засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилсэн мэдээллийн 79%-ийг дангаар гаргасан байна.

Улаанбаатар хотын захирагч болон нийслэлийн ЗДТГ-ын үйл ажиллагааг магтан сайшаасан нэг талын тэнцвэргүй мэдээллийг MN25 суваг, UBS болон МҮОНТ-ээр цацагджээ. Харин сонгогчийн боловсролд зориулсан цаг үеийн мэдээ, тодруулах ярилцлага зэргийг NTV, МҮОНТ телевизүүд бусдаас илүү гаргасан боловч мэдээллийн агуулгын хувьд NTV телевиз сонгогчдод хэрэгцээтэй мэдээллийг задлан шинжилж харуулахыг зорьсон бол МҮОНТ цаг үеийн шинжтэй мэдээллийг илүүтэй хүргэсэн байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуульд өрсөлдөж буй намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчид нь хэн нь хэн бэ? гэдгийг мэдээлэх нь иргэний мэдэх эрхийг хангах наад захын мэдээлэл юм. Үүнээс цаашлаад тухайн нэр дэвшигчийг хэн болох, өмнө нь ямар түүхийг бүтээсэн тухай, мөн өрсөлдөгч намуудын дэвшүүлж буй бодлого, амлалтуудыг задлан шинжилж, хэрэгжих боломжтой эсэхийг дүгнэж цэгнэсэн, сонгогчдод сонгох эрхээ хэрхэн зөвөөр эдлэх тухай мэдлэг олгосон олон талт мэдээллийг үргэлжлүүлэн түгээх нь мөн л хэвлэл мэдээллийн үүрэг болдог.

Гэвч Сонгуулийн тухай хуулийн 48.1.17-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессэж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах”-ыг хориглосон нь сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа болох улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг нарийвчлан задлан шинжилж, харьцуулалт хийх, мөн нэр дэвшигчдийг хэн нь хэн бэ гэх зэргээр харьцуулан жишихийг хориглосон нь аналитик сэтгүүл зүйн үйл ажиллагаанд бодит саад болж байсныг редакторууд¹¹ онцолж байв.

Сонгуулийн үед хэвлэл мэдээллийн байгууллагууд иргэний мэдэх эрхийг хэр хангаж ажилласныг тэдгээрийн нийтэлж нэвтрүүлсэн мэдээ, сурвалжилга, нийтлэл нэвтрүүлэг нь хэр тэнцвэртэй байснаар хэмжигддэг. Мэдээллийн тэнцвэрт байдал гэдэг нь олон талын байр суурийг тусгасан, олон ургальч байдлыг хангасан, сэтгүүл зүйн бүтээлийн шалгуур үзүүлэлтийн дагуу дор хаяж 2-3 түвшний эх сурвалжийн төлөөллөөр мэдээллийг баталгаажуулснаар хэмжигдэнэ. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйд сонирхлын, үр дагавар хүртэгсдийн болон мэргэжилтний гэсэн гурван бүлгийн /түвшний/ төлөөллийг жигд хамруулснаар мэдээллийн найдвартай бөгөөд баталгаатай байдал төдийчинээ дээшилдэг. Мониторингийн дүнгээс харахад, телевизүүд төлбөрт сурталчилгааны хүрээнд нэр дэвшигч улс төрийн бүхий л намыг жигд хамруулж чадаагүй бөгөөд парламентад суудалтай МАН, АН, МАХН-ын мэдээлэл давамгайлж, харин парламентад суудалгүй намуудын мэдээлэл бага хувийг эзэлж байв.

¹¹ ХМЗ, ФЭС хамтран зохион байгуулсан “Сонгуулийн үеийн эрх зүйн зохицуулалт ба ёс зүй” сэдэвт дугуй ширээний ярилцлага, 2020-10-28, УБ хот

График 4. Эх сурвалжийн олон талт байдлыг хэрхэн хангав /Эх сурвалжийн түвшин

**Сонгуультай холбоотой нийт мэдээллээс тооцов.*

Мониторингийн хугацаанд судлаачид нийт 3074 эх сурвалжийг бүртгэж авсан бөгөөд нийт мэдээний 62 хувьд нь нэг түвшний эх сурвалжууд багтсан бол сэтгүүл зүйн тэнцвэрт байдлыг хангах эх сурвалжийн гурван түвшинг хангасан мэдээ байхгүй байгаагаас сонгуулийн үеийн сэтгүүл зүйн тэнцвэрт байдал хангагдсангүй. Ийнхүү телевизүүд сонгуулийн хугацаанд мэдээллийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллаагүй нь “бэлэн материал” буюу төлбөрт болон далд сурталчилгааны мэдээллийг түлхүү нэвтрүүлсэнтэй холбоотой юм.

Төлбөртэй сурталчилгаанд нэг талын байр суурь давамгайлж, мэдээллийн тэнцвэрт байдал хангагдахгүй нь ойлгомжтой бөгөөд төлбөртэй мэдээллийг редакцын бүтээлээс ялгаж таниулах тэмдэг тэмдэглэгээ ашиглах нь редакцын ёс зүйн үүрэг юм. Гэвч телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт “сонгууль” гэсэн таних тэмдэглэгээг багц хөтөлбөрийнхөө өмнө оруулж өгсөн боловч үүнээс сонгогчид “төлбөртэй мэдээлэл” гэдгийг шууд ялгаж таних боломж хомс байсныг судлаачид тэмдэглэсэн байна.


Түүнчлэн сонгуулийн үйл явдлыг сэтгүүлч хөндөхдөө ихэвчлэн нэг л түвшний эх сурвалжийг оролцуулжээ. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч тодорхой асуудал хөндөж мэдээ бэлтгэхдээ нэг намын гурван хүнээс тодруулга аваад өрсөлдөгч тал, үр дагавар хүртэгч сонгогчдын дуу хоолойг тусгахгүй байх нь нийтлэг ажиглагдлаа. Мөн сонгогч иргэнээс тодруулга авах, байр суурийг нь сонсохдоо хөндөж буй сэдвээсээ хамааран дан ганц магтсан талууд эсвэл муулсан талын байр суурийг үзүүлж байгаагаас мэргэжлийн сэтгүүл зүйн суурь зарчмууд сонгуулийн үед хэрэгжсэнгүй. ТВ тус бүрээр харвал, МҮОНТ бусдаасаа илүү буюу сэтгүүл зүйн мэдээнийнээ 24.5%-д хоёр түвшний эх сурвалжийг хамруулсан байв.

Хүснэгт 4. Эх сурвалжийн олон талт байдлыг хэрхэн хангав / ТВ тус бүрээр харьцуулбал

	МҮОНТ	NTV	ТВ9	MN25	UBS	Нийт
Эх сурвалжийн 1 түвшин	18.9%	20.5%	26.1%	21.6%	12.9%	100.0%
Эх сурвалжийн 2 түвшин	25.4%	18.7%	20.1%	15.5%	20.3%	100.0%

*Сонгуультай холбоотой нийт мэдээллээс тооцов.


Түүнчлэн дор хаяж хоёр түвшний эх сурвалжийг хамруулсан мэдээний 40% нь төлбөртэй сурталчилгаа байгаа бол 19,4% нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл байв.

График 5. Эх сурвалжийн олон талт байдлыг хэрхэн хангав /Эх сурвалжийн түвшин/ мэдээллийн төрөл

*Сонгуультай холбоотой нийт мэдээллээс тооцов.

2.1. Мэдээллийн хөтөлбөр дундуурх төлбөртэй сурталчилгаа

Сонгуультай холбоотой нийт мэдээллийн **85%** (1120 мэдээлэл) нь төлбөртэй сурталчилгаа байв. Өөрөөр хэлбэл, сонгуулийн сурталчилгааны үед дунджаар дурын телевизийн нэг өдрийн мэдээллийн хөтөлбөрийн **1,313 секунд буюу 22 минутад** төлбөртэй сурталчилгаа цацагджээ.

График 6. Төлбөртэй сурталчилгаа /сурталчилгааны хоног/ өсөлтийн хувиар

Улаан шугам - Өсөлтийн муруй (хувиар)

Телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрийг задлан харахад, **МАН**-ын тухай мэдээлэлд хамгийн их хугацааг (**54 минут**) зарцуулсан байна. Доорх хүснэгтээс харвал, мониторингт хамрагдсан бүх телевизүүд мэдээллийн хөтөлбөртөө МАН болон АН-ын тухай мэдээлэл түгээхдээ УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 46.14 дэх заалтыг зөрчин оногдсон цагийг хэтрүүлэн ашиглажээ. **ТВ9** телевиз мэдээллийн хөтөлбөртөө **Та бидний эвслийн** талаар мэдээлэхдээ мөн хуулиар олгогдсон цагийг хэтрүүлэн ашигласан байна.

МУ-ын УИХ-ын сонгуулийн тухай хууль. 46.14-р заалт:

*Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар мэдээг **хоногт 5 минутаас хэтрүүлэхийг хориглоно.***

Хүснэгт 5. Төлбөртэй сурталчилгаа / хоногт дунджаар намуудад зарцуулсан хугацаа (минутаар) / ТВ тус бүрээр


	MN25	NTV	TV9	UBS	МҮОНТ	Нийт
МАН	14.5	9.5	8.3	13.0	8.7	54.1
АН	6.5	10.4	7.8	5.5	5.3	35.6
Та бидний эвсэл	0.3	0.6	9.2	0.1	1.7	11.9
Зөв хүн электорат эвсэл	0.4	0.2	0.1	0.3	0.9	2.0
Шинэ эсвэл	0.1	0.0	0.5	0.4	0.6	1.6

Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл	0.1	0.2	0.8	0.1	0.1	1.3
Бусад нам бие даагч	1.0	0.3	0.8	0.9	0.8	3.9

Телевиз тус бүр намуудад нэг хоногт зарцуулсан хугацааг минутаар илэрхийлэв.


Хугацааг минутаар илэрхийлэхдээ меан буюу арифметик дундажаар тооцов.

График 7. Төлбөртэй сурталчилгаа / ТВ тус бүрээр



Дээрх графикаас харахад ТВ9 телевизийн сонгуультай холбоотой мэдээллийн 24,8 хувь нь, NTV-ийн 21,3 хувь төлбөртэй сурталчилгаа байв.

График 8. Төлбөртэй сурталчилгаа / нам, эвслээр харьцуулсан



Төлбөртэй сурталчилгаа дотроо МАН-ын сурталчилгаа 48,4 хувийг эзэлж байгаа бол АН-ынх 31,6 хувийг эзэлсэн байна. Харин Шинэ эвсэл болон Зөв хүн электорат эвсэлийн талаарх мэдээлэл 2-3 орчим хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 6. Төлбөртэй сурталчилгаа / сонгуулийн сурталчилгааны 21 хоногт намуудад зарцуулсан нийт хугацаа (минутаар) / ТВ тус бүрээр

Нам, эвсэл, нэр дэвшигч	Давтамжаар	Үргэлжилсэн хугацаа	
		Секундээр	Минутаар
МАН	563	68,177	1,136.3
АН	357	44,838	747.3
Та бидний эвсэл	121	15,010	250.2
Зөв хүн электорат эвсэл	29	2,540	42.3
Шинэ эсвэл	19	2,010	33.5
Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл	14	1,665	27.8
Бусад нам, бие даагч	47	4,890	81.5
Нийт	1,150	139,130	2,318.8

*Сонгуулийн сурталчилгааны 21 хоногт

Сонгуулийн сурталчилгааны үеэр телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд **МАН**-ын тухай хамгийн олон удаа (**563 удаа**), хамгийн урт хугацаагаар (**68,177 секунд буюу 1,136 минут**) төлбөртэй сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Төлбөртэй сурталчилгаа / Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын зөрчил

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд мэдээллийн хөтөлбөрөөрөө төлбөртэй сурталчилгаа нэвтрүүлэхдээ ямар нэгэн байдлаар “төлбөртэй мэдээлэл” хэмээн ойлгогдохуйц ялган таних тэмдэг, тэмдэглэгээ, дүрс, үг хэллэг ашигласан байв. Тухайлбал: төлбөртэй мэдээллийг нэвтрүүлэхийн өмнө титрээр болон “Сонгууль 2020” гэсэн шторкоор ялгаж өгөх, эсвэл “Аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн штабаас мэдээллээ” гэх зэрэг үг, хэллэгээр ялган зааглаж байв.

Гэсэн хэдий ч редакцын зүгээс тухайн мэдээлэл нь төлбөртэй буюу редакцын байр суурийг илэрхийлээгүй, мөн сэтгүүл зүйн үйл ажиллагаа хийгдээгүй сурталчилгааны материал гэдгийг илүү тодорхой харуулах, төлбөртэй мэдээлэл дамжуулж байгаа гэдгээ шууд илэрхийлэхгүй байгаа нь энгийн үзэгчийн хувьд редакцын бүтээл хэмээн төөрөлдөх, төлбөрт мэдээллийг ялгаж зааглаж мэдэхгүй байх нь сэтгүүл зүйн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.


Телевизийн мэдээллийн хөтөлбөр дундуур цацагдсан төлбөртэй сурталчилгаануудад бусдыг үзэн ядах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үг хэллэгийг ашигласан тохиолдол

бүртгэгдээгүй нь сайшаалтай. Энэ нь редакцууд төлбөртэй мэдээллийг цацахын өмнө хуулийн заалт болон ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг урьдчилан нягталж шалгаж байгаагийн илрэл болов уу.

2.2. Далд сурталчилгаа

Нийт мэдээллийн **8%** (106 мэдээлэл) нь далд сурталчилгаа байв. Өөрөөр хэлбэл сонгуулийн сурталчилгааны үед дунджаар дурын телевизийн нэг өдрийн мэдээллийн хөтөлбөрөөр **169.5 секунд буюу 2.8 минутын** далд сурталчилгаа цацагдсан байна.

График 9. Далд сурталчилгаа / сурталчилгааны хоног / өсөлт, бууралтын хувиар




Улаан шугам – Өсөлт, бууралтын муруй (хувиар)

Ёс зүйн зарчим 9:


Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.

График 10. Далд сурталчилгаа / ТВ тус бүрээр



Сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны хугацаанд цацагдсан нийт далд сурталчилгааны гуравны нэгийг **МҮОНТ**, дөрөвний нэгийг **MN25 суваг ТВ нэвтрүүлсэн бол NTV** телевизээр далд сурталчилгаа цацагдсангүй.


График 11. Далд сурталчилгаа / нам, эвслээр



Нийт далд сурталчилгааны 94 хувь нь буюу ойролцоогоор арван далд сурталчилгаа тутмын ес нь **МАН**-ын тухай байна. Энэ нь МҮОНТ-ээр цацагдсан эрх баригч нам, МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа ажлууд, КОВИД-19 цар тахлын эсрэг хийж буй Улсын онцгой комисс, ЭМЯ зэргийг тойрсон магтан сайшаасан, дэмжсэн мэдээллүүд мөн ТВ9 телевизээр цацагдсан эрх баригч намын бодлого, үйл ажиллагааг шүүмжилсэн сөрөг мэдээллүүд багтаж байна.

Харин парламентад суудалгүй нам эвслүүд болох Зөв хүн электорат эвсэл, Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл болон Шинэ эсвэл бусад нам эвслийн талаар ямар нэгэн далд сурталчилгаа бүртгэгдсэнгүй.

График 12. Мэдээллийн хөтөлбөрт эзлэх далд сурталчилгааны хувь



Хүснэгт 7. Далд сурталчилгаа / нам, эвсэл, нэр дэвшигч / давтамж / хугацаагаар

Нам, эвсэл, нэр дэвшигч	Давтамжаар	Үргэлжилсэн хугацаа	
		Секундээр	Минутаар
МАН	99.0	16,720.0	278.7
АН	2.0	180.0	3.0
Та бидний эвсэл	1.0	240.0	4.0
Зөв хүн электорат эвсэл	1.0	60.0	1.0
Шинэ эсвэл	1.0	60.0	1.0
Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл	-	-	-
Бусад нам, бие даагч	4.0	600.0	10.0
Нийт	108.0	17,860.0	297.7

*Сонгуулийн сурталчилгааны 21 хоногт

Телевизүүд мэдээллийн хөтөлбөрөөрөө **МАН**-ын тухай хамгийн олон давтамжтайгаар (**99 удаа**), хамгийн урт хугацаагаар (**16,720 секунд буюу 278.7 минут**) далд сурталчилгаа явуулжээ.

Хүснэгт 8. Далд сурталчилгааны агуулга / нам, эвслээр харьцуулсан

Мэдээллийн агуулга	МАН	АН	Та бидний эвсэл	Бие даагч	Нийт
Засгийн Газар болон түүний харьяа яам, агентлагууд (ЭМЯ, ГХЯ, УОК)-ын үйл ажиллагаа болон Ерөнхий сайд, эрх баригч намын үйл ажиллагааны тухай (магтсан, сайшаасан, дэмжсэн)	95.5%	0.0%	1.5%	3.0%	100.0%
Хотын захирагч болон НЗДТГ-тай холбоотой цаг үеийн шинжтэй үйл явдлын мэдээлэл (магтсан, сайшаасан, дэмжсэн)	100.0%	0.0%	0.0%	0.0%	100.0%
Засгийн газрын үйл ажиллагаа, эрх баригч намыг шүүмжилсэн.	94.4%	5.6%	0.0%	0.0%	100.0%
УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн шүүх хуралтай холбоотой цаг үеийн мэдээлэл	50.0%	0.0%	0.0%	50.0%	100.0%

Дээрх хүснэгтээс харахад МАН-ыг магтсан болон шүүмжилсэн өнгө аяс бүхий далд сурталчилгааны эзлэх хувь ойролцоо буюу 95% байна. Харин нийслэлийн удирдлагатай холбоотой далд сурталчилгаа нь бүгд эерэг өнгө аясыг агуулжээ.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд далд сурталчилгааг зөвшөөрдөггүй

Ёс зүйн зарчим 1.5:

Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.

Ёс зүйн зарчим 9.1:

Далд сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана.

Далд сурталчилгаа гэдэгт сэтгүүл зүйн төрөл жанрыг ашиглан мэдээ сурвалжилгыг бэлтгэхдээ сонгуульд оролцогч нам эвслүүд, нэр дэвшигчдэд ижил тэгш боломж олгохгүйгээр, тэдний бодлого үйл ажиллагааг шударгаар харьцуулан олон нийтэд шийдвэр гаргах, сонголт хийхэд нь туслахгүйгээр аль нэг талыг илт магтан сайшаах, эсвэл буруутган муулах, суртал ухуулга (пропоганда), тархи угаах (манипулаци) өнгө аясаар нийтэлж нэвтрүүлэхийг багтаан ойлгодог.

Түүнчлэн далд сурталчилгаа нь үйл явдалд оролцогч талуудын байр суурийг тэгш бөгөөд тэнцвэртэй хангаагүйн улмаас аль нэг талд илт давуу байдлыг олгох, эсвэл аль нэг талыг илт үндэслэлгүйгээр буруутгах зэргээр сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээний зөрчилд хүргэдэг тул ийм зүйл нийтэлж, нэвтрүүлэхийг ёс зүйн зарчмын хүрээнд хориглодог.

Гэвч сонгуулийн сурталчилгааны хугацаанд өдөрт дунджаар 3 минутын далд сурталчилгаа хэлбэрийн мэдээлэл түгээгдсэнийг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын **1.5 дах заалт буюу Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана. 9.1 дэх заалт буюу Далд сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана** гэсэн заалтуудыг зөрчсөн хэмээн үзэж байна. Мониторингийн дүнгээс харахад, өргөн нэвтрүүлгийн телевизүүд мэдээллийн хөтөлбөрөөрөө дамжуулан далд сурталчилгаа хийх нь сонгогчдын үнэн бодит мэдээлэл авах эрхийг зөрчиж, ухуулан сурталчлах, ятган үнэмшүүлэх, мушгин гуйвуулах

зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйд харш үйлдэл хийж байна хэмээн дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, нийт далд сурталчилгааны **82%** нь **нэг талын байр суурийг илэрхийлэхдээ илт магтан сурталчилсан, 18%** нь **нэг талын байр суурийг илэрхийлэхдээ илт муулан шүүмжилсэн** агуулгатай мэдээлэл байна.

Далд сурталчилгааны 69% нь эх сурвалжийн нэг түвшинг ашигласан бөгөөд үлдсэн 31% нь эх сурвалжийн хоёр түвшинг хамруулсан боловч нэг л талын байр суурийг илэрхийлсэн ажээ.

Далд сурталчилгааны зарим жишээг дурдвал: **МҮОНТ** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр дундуураа “Уханиас ирсэн оюутнууд Засгийн газар, УОК-т баярлаж талархаж байна. Иргэдээ цар тахлын голомтоос маш түргэн шуурхай зохион байгуулалттайгаар татаж авсанд баярлаж, тэднээр бахархаж байна. **Засгийн газар, УОК-д баярлалаа**”, “Цар тахлыг дотооддоо алдаагүй засгийн газартаа **баярлалаа, тэдэнд таларх залуу минь**”, “Монгол залуус, монгол инженерүүд өөрсдөө гурав дахин бага зардлаар төмөр замаа барьж байна. **Монгол улсын төлөө зүтгэе**”, “Монгол залуус өөрсдөө төмөр замаа барьж байна. **“Эх орны төлөө зүтгэе”**”, “Уурхайчдын бүтээсэн ололтыг онцолсон. **#БАЯРЛАЛАА**. Монгол улсын төлөө зүтгэе”, “Таван толгой түлшний үйлдвэрийг нээв. Утааг 50 хувь буурууллаа. **“Монгол улсын төлөө зүтгэе”**”, “Сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлээр цар тахлын талаарх мэдээллийг мэдээлж байна. **“Засгийн газар, ЭМЯ, УОК-д баярлалаа”** гэх мэт засгийн газрын үйл ажиллагааг илт магтан сурталчилсан, дэмжихийг уриалан дуудсан шторк нийт **9 удаа** цацагдав.

Дээрх шторкуудын “**Засгийн газар, УОК-д баярлалаа**”, “**Засгийн газартаа баярлалаа, тэдэнд таларх залуу минь**”, “**Монгол улсын төлөө зүтгэе**”, “**Эх орны төлөө зүтгэе**”, “**#БАЯРЛАЛАА**” гэсэн үгнүүд нь **толгой үсгээр, тод улаан өнгөөр** бичигдсэн байгаа нь анхаарал татахуйц байсныг энд дурдах хэрэгтэй.

Тус шторк нь нэг талаас төлбөртэй эсэх нь тодорхойгүй, нөгөө талаас шууд сонгуулийн сурталчилгаа гэж дүгнэхэд хэт өрөөсгөл агуулгатай ч цаад далд утга санаа, зорилго нь Засгийн

газар, эрх баригч намыг илт сурталчилсан, тэднийг дэмжихийг уриалсан, саналаа өгөхийг сануулсан байсныг онцлон тэмдэглэж байна.

Мөн түүнчлэн цаг үе, үйл явдлын шинжтэй мэдээ, сурвалжилга хэдий ч Засгийн газрын гишүүд, сайд нар, хотын захирагч зэрэг нийтийн албан тушаалтнуудын (Ерөнхий сайд У.Хүрэлсүх, ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл, ГХ-ны сайд Д.Цогтбаатар, Улсын онцгой комисс (УОК)-ын дарга Ө.Энхтүвшин, Уул уурхайн сайд Д.Сумьяабазар, Хотын захирагч С.Амарсайхан гэх мэт) үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг гаргахдаа тухайн хүмүүсийн зураг, дүрсийг олон дахин давтаж гаргах, удаа дараа эх сурвалж болгох, тодруулга мэдээлэл, яриа авах зэрэг жишээнүүдийг дурдаж болно. Эдгээр улс төрийн албан тушаалтнуудыг онцгойлон эш татаж байгаа нь дээрх нэр бүхий улс төрчид бүгд сонгуульд нэр дэвшин өрсөлдөж байсан юм.

Далд сурталчилгааны агуулгаас зарим жишээг дурдвал “Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Уул уурхайн сайд Д.Сумьяабазар нар Таван толгой зүүн баян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа”, “МУ-ын Шадар сайд Оюу толгойн Гүний далд уурхайн бүтээн байгуулалттай танилцлаа”, “УОК-оос цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон үйлчилгээний ажилтнуудад түрээслээд өмчлөх нөхцөлтэйгээр олгох орон сууц олгоно”, “Өрх бүрт хүнсээ бэлтгэе» уриатай хаврын тариалалт 90 хувьтай явагдаж байна”, “Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар: Засгийн газар том мега төслүүд эхлүүлээ”, “ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийг дэмжих төвийн нээлтэд оролцлоо” гэх мэтээр суртал ухуулгын шинжтэй (Пиар мэдээлэл) мэдээллүүдийг хэлж болно.

Үүнээс гадна телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт иргэдийн дуу хоолойг гаргахдаа тэнцвэртэй бус, зориудаар бэлтгэсэн мэт хэт нэг талыг барьсан, сайшааж магтсан, дэмжсэн өнгө аясыг тээсэн байв. Эдгээр мэдээллийн агуулга нь **“Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлсэн, шахмал түлш хэрэглээнд нэвтэрснээр агаарын бохирдол эрс багассан, хавдрын эсрэг үндэсний аяны тухай, уул уурхайн баялаг ард иргэдэд үр өгөөжөө өгч байгаа”** талаар хөндсөн болно.


Хэт нэг талыг барьж дагнан шүүмжилсэн агуулгатай мэдээллийн **79%**-ийг **TV9** телевиз, **21%**-ийг **MN25** телевиз нэвтрүүлсэн байна. Шүүмжилсэн жишээнүүдээс дурдвал **MN25** сувгийн **"25 цаг"** мэдээллийн хөтөлбөрөөр *"Малчдад олгох ямааны ноолуурын нэг килограмм тутамд өгч буй 20,000 төгрөгийн татаасыг ямааны тоо толгойг шалгахгүйгээр дансанд нь шууд шилжүүлж байна. Сонгуулийн дараа ямааны тоо толгойг тулгаж үзээд зөрүү гарвал мөнгийг нь буцааж авна гэж байгаа нь Ч.Улаан сайдын сонгуулийн популист амлалт"* хэмээн шүүмжилжээ.

TV9 телевизийн **"Энэ өдөр"** мэдээллийн хөтөлбөрөөр *"Өрөнд баригдсан төрийн бодлого МУ-ыг дампууруулахад хүргэж байна. Сонгууль болтол төсвийн тодотгол хийхгүй", "КОВИД-19" цар тахлын үеийн сонгуулийн сурталчилгааны үеэр авч хэрэгжүүлэх онцгой үед ажиллах дүрэм, журам батлагдаж, мөрдөгдөж байгаа ч ерөнхий сайд У.Хүрэлсүх өөрийн гаргасан журмаа Нарантуул зах болон Орхон аймагт сонгогчидтой хийсэн уулзалтын үеэр мөрдөөгүй, сонгогчдыг олноор нь цуглуулж, тэврэлдэх гэх мэтээр журмыг зөрчиж байна", "Дарханы зам ашиглалтанд орохгүй байгаатай улбаалж тус зам дээр 243 хүн зам тээврийн ослоор амиа алдсан нь Корона вирусээс илүү аюултай нөхцөл байдал үүсч байна", "УИХ-ын сонгуулийн сурталчилгааны ажилд нийт 240 тэрбум төгрөг зарцуулагдаж байна, энэ мөнгөөр эмнэлэг, сургууль, цэцэрлэг гэх мэт бусад хэрэгтэй зүйлд зарцуулж болох байлаа"* хэмээн шүүмжилжээ.

2.3 Сонгогчийн боловсролд зориулсан мэдээлэл

Нийт мэдээллийн **7.4%** (98 мэдээлэл) нь сонгогчийн боловсролд чиглэсэн мэдээлэл байв. Өөрөөр хэлбэл сонгуулийн сурталчилгааны үед дурын телевизийн нэг өдрийн мэдээллийн хөтөлбөрт дунджаар **194.6 секунд буюу 3.2 минутыг** сонгогчдын боловсролд чиглэсэн мэдээлэлд зарцуулсан байна.


График 13. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл /сурталчилгааны хоног / бууралтын хувиар



Улаан шугам – Бууралтын муруй (хувиар)

Сонгогчдын боловсролд чиглэсэн мэдээлэл сонгуулийн сурталчилгааны эхний долоо хоногт хамгийн олон давтамжтай байсан бол сурталчилгааны сүүл үе гэхэд хоёр дахин буурчээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийн сурталчилгааны эхэн үед телевизүүд сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэлд илүүтэй ач холбогдол өгч түлхүү нэвтрүүлж байсан бол сонгуулийн сурталчилгааны сүүлийн долоо хоногуудад аажмаар буурч харин төлбөртэй болон далд сурталчилгааны мэдээлэлд дийлэнх цагаа зориулсан нь өсөлт/бууралтын муруй шугамаас тодорхой харагдаж байна.

График 14. Сонгогчдын боловсролд чиглэсэн мэдээлэл / ТВ тус бүрээр



Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийг түгээхэд МҮОНТ-ээс гадна арилжааны телевизүүдээс NTV телевиз илүү үүрэг гүйцэтгэжээ. МҮОНТ нь сонгогчдод зориулсан цаг үеийн шинжтэй мэдээллийг хүргэж байсан бол NTV телевиз нь “Хэрсүү сонголт” гэсэн 20 минутын тусгай буланг мэдээллийн хөтөлбөртөө шигтгэн оруулж сонгогчдын мэдлэг, сонголтод тус болох мэдээллийг явуулсан байна.

NTV телевиз сонгуулийн хугацаанд “Хэрсүү сонголт” булангаа тогтмол хөтөлж чадаагүй ч мэдээллийн хөтөлбөртөө сонгогчдын боловсролд зориулсан 5-15 минутыг тогтмол зориулж ажилласан байна. Эдгээрт хуульч, шинжээчдийг оролцуулан сонгогчдын хувьд анхаарал татаж буй тойргуудыг онцлон тус тойрогт нэр дэвшигчдийн түүх намтар, хийж бүтээсэн ажлууд, нийгэмд оруулсан хувь нэмэр, хөрөнгө орлогын мэдүүлэг, мөн намууд мөрийн хөтөлбөртөө юу тусгасан зэрэг мэдээллийн эргэн тойронд хэн хэн нэр дэвшиж буйг танилцуулан сонгогчдод мэдлэг олгохыг зорьжээ.

Тухайлбал, NTV телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө дамжуулан сонгогчдод дараах мэдлэг мэдээллийг хүргэсэн байна.

- Сонгуулийн үеэр иргэдтэй хийх уулзалтын журам батлагдсан тухай
- Намын дарга нарын хөрөнгө орлогын мэдүүлэг
- Намуудын мөрийн хөтөлбөрт татварын бодлого хэрхэн туссан бэ
- Боловсролын салбарт хамаарах онцлох амлалтууд
- Эрүүл мэндийн салбарт хамаарах онцлох амлалтууд
- Мөрийн хөтөлбөрүүдээс мега төслүүдийг онцолж байна
- Залуучуудыг дэмжих чиглэлээр намууд юу амалж байна
- Залуучууд сонгуулийн үйл явцыг хэрхэн хянах вэ
- Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15-19 хувь байна
- 2016 оны УИХ-ын сонгуулиар 10 залуу тутмын 6 нь саналаа өгөөгүй
- Нэр дэвшигчид хоёр хоногт 50-100 долларыг төлбөртэй постод зарцуулж байна гэх мэт.

МҮОНТ нь мэдээллийн хөтөлбөр дундуур сонгогчдын мэдлэг, мэдээлэлд зориулсан дараах мэдээг түгээж байсан тул эдгээрийг сонгогчдын боловсролд зориулсан хэмээн бүртгэж авав. Тухайлбал:

- Сонгуулийн тойргууд болон мандатын талаарх танилцуулга мэдээлэл
- Тусгаарлалтад байгаа иргэд сонгуульд оролцож саналаа өгөх боломжгүй гэдгийг ОБЕГ болон ЭМЯ-наас мэдээлсэн тухай
- УИХ-ын 2020 оны сонгуульд ямар нам, эсвэл, нэр дэвшигчид өрсөлдөж байна, мөн тэдгээрийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн амлалт, уриа зэргийг харьцуулсан мэдээлэл
- Улс төр судлаачид сонгуульд оролцохын ач холбогдолыг онцлон сонгуулийн оролцооны талаарх тоо баримтын мэдээлэл
- Санал өгөх зарчим, санал өгөх журам, тойргуудын тухай мэдээлэл
- УИХ-ын сонгуульд нэр дэвшигч 7 хүнтэй холбох шүүх хурлын талаар
- Жил бүрийн сонгуулийн ирцийн талаарх мэдээлэл
- Санал авах байруудыг цагдаагийн албан хаагчид хамгаалалтад авч ажиллаж буй тухай
- МҮОНРТ мэдээллийн тэгш байдлыг хангах үүднээс нэр дэвшигч бүрт 15 минутыг гаргаж өгч байгаа тухай мэдэгдэл гэх мэт.

График 15. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн төрөл




Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн гуравны нэг нь сонгогчдын нэрсийн жагсаалт, санал өгөх зарчим, сонгуулийн ирц, сонгуулийн тойргууд, мандатын тухай мэдээлэл байгаа бол дөрөвний нэг нь сонгуулийн тухай хууль бусад холбогдох хуулийн тодорхой заалтуудын тайлбар, хэрэгжилт, хяналтын тухай мэдээллүүд байна.

Хүснэгт 9. Редакцын сэдэв сонголт / Сонгогчдын боловсролд зориулсан мэдээний агуулга

Мэдээллийн агуулга	Давтамж	Хувь
Сонгогчдын нэрсийн жагсаалт, санал өгөх зарчим, сонгуулийн ирц, сонгуулийн тойргууд, мандатын тухай	32	32.7%
Сонгуулийн тухай хууль бусад холбогдох хуулийн тодорхой заалтуудын тайлбар, хэрэгжилт, хяналт	24	24.5%
Намуудын мөрийн хөтөлбөр	11	11.2%
Авлига албан тушаалын хэрэгт холбогдсон нэр дэвшигчдийн тухай цаг үеийн мэдээлэл	10	10.2%
ЖДҮ зээл авсан гишүүд, нэр дэвшигчдийн хэн нь хэн бэ? нэр дэвшигчид хэрхэн хуулийн хүрээнд өрсөлдөх вэ	7	7.1%
Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн боловсролд чиглэсэн, сонгуулийн ач холбогдол, саналын үнэ цэнэ	7	7.1%
Нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэг	5	5.1%
СЕХ-ноос хийсэн цаг үеийн мэдээлэл	2	2.0%
Нийт	98	100.0%

Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн 81% нь эх сурвалжийн нэг түвшинг, үлдсэн 19% нь эх сурвалжийн хоёр түвшинг хамруулсан байна.

График 16. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээний эх сурвалжийн олон талт байдал


Сонгогчдын боловсролд зориулсан хоёр түвшний эх сурвалжтай гурван мэдээлэл тутмын нэг нь сонгуульд нэр дэвшигчдийн тухай, дөрвөн мэдээлэл тутмын нэг нь УИХ-ын сонгуулийн хуулийн тухай мэдээлэл байлаа. Өөрөөр хэлбэл редакц сонгуульд нэр дэвшигчдийн тухай цаг үеийн мэдээлэл бэлтгэх мөн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн хэрэглээ, тайлбарын талаар мэдээлэл бэлтгэхдээ, талуудын байр суурийг тусгахыг эрмэлзсэн, холбогдох эх сурвалжуудаар баталгаажуулахыг зорьжээ.

Хүснэгт 10. Эх сурвалжийн хоёр түвшинг хамруулсан сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн агуулга

Мэдээллийн агуулга	Давтамж	Хувь
УИХ-ын сонгуулийн тухай хуулийн тайлбар (хуулийн зүйл заалтуудыг тайлбарлах)	5	26%
Сонгогчдын нэрсийн жагсаалтад хэрхэн бүртгүүлэх, яаж шалгах, хэрхэн хянах, хэрхэн баталгаажуулах, яаж гомдол гаргах гэх мэт	2	11%
Сонгогчдын ирц, сонгуулийн оролцоо, сонгуулийн ач холбогдлын талаар	3	16%
Сонгуульд нэр дэвшигчдийн тухай цаг үеийн мэдээлэл	6	32%
Бусад.....	4	21%
Нийт	19	100%

Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл нь холбогдох баримт бичиг, хууль, дүрэм, журмаас эшлэх зэргээр ихэвчлэн баримтад тулгуурлажээ.

График 17. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн баримтын төрөл



2.4. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хэрэгжилт

Сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны үеэр мониторингт хамрагдсан өргөн нэвтрүүлгийн телевизүүд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн 2015 оны 4-р сард батлагдсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг хэрхэн баримталж ажилласанд ажиглалт хийхэд ёс зүйн зарчмын 1.5 дахь заалт болох Нөлөөллийн болон Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана. 9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана. 9.1 Далд сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана гэсэн заалтуудыг нийтлэг зөрчжээ. Харин Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дараах заалтуудыг сонгуулийн үеэр телевизүүд зөрчсөн эсэхэд ажиглалт хийхэд тодорхой кейс бүртгэгдээгүй болно.

Ёс зүйн зарчим 1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, ишлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.

Ёс зүйн зарчим 1.6 Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана.

Ёс зүйн зарчим 1.8 Буруутгагдсан шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.

Ёс зүйн зарчим 3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.

Ёс зүйн зарчим 4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.

Ёс зүйн зарчим 5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.

Ёс зүйн зарчим 10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.

III. **Хэсгийн дүгнэлт**

- Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн төлөөлөл болох үзэгчдийн хүртээмжтэй таван телевизийн мэдээллийн хөтөлбөрийн 6300 минутын 1324 мэдээ, мэдээлэлд УИХ-ын 2020 оны сонгуулийг хэрхэн мэдээлж сурвалжилсанд хөндлөнгийн мониторинг хийлээ.

- Мониторингийн дүнгээр УИХ-ын сонгуулийн кампанит ажлын 21 хоногийн хугацаанд судалгаанд хамрагдсан телевиз бүр өдөрт дунджаар нэг цагийн мэдээллийн хөтөлбөрийг телевиз үзэлтийн оргил цаг буюу 19:00-21:00 цагийн хооронд үзэгчдэд хүргэжээ. Үүний **47** хувь нь сонгуулийн тухай мэдээ мэдээлэлд зориулагдсан бол үлдсэн хувь нь цаг үеийн бусад мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа, цаг агаарын мэдээ, дэлхийн дахины үйл явдлын мэдээ зэргийг агуулжээ.

- Телевизүүдийн түгээсэн сонгуулийн сэдэвт мэдээ мэдээлэлд нарийвчлан шинжилгээ хийхэд **84,6** хувь нь “бэлэн” төлбөртэй сурталчилгаа буюу аль нэг нам, эсвэл, нэр дэвшигчдээс бэлтгэн ирүүлсэн сэтгүүл зүйн бус пиарын (PR) мэдээлэл, **8** хувь нь эрх баригч МАН, Засгийн газар, НЗДТГ-ын үйл ажиллагааг магтаж сайшаасан дэмжсэн далд сурталчилгаа, үлдсэн **7,4** нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл байв. Үүнээс харахад, телевизүүдийн нэвтрүүлсэн сонгуулийн тухай мэдээллийн 90 гаруй хувь нь ил болон далд сурталчилгаанууд байсан бол 7 гаруйхан хувь нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл байлаа.

- Сонгуулийн сурталчилгааг телевизүүд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 46.14-т заасны дагуу нам, нэр дэвшигчдэд ижил тэгш боломж олгон тэдний зүгээс ирүүлсэн сурталчилгааны материалыг нэвтрүүлсэн ч МАН, АН болон Та бидний эвслийн талаарх мэдээлэлд хуулиар олгогдсон 5 минутыг хэтрүүлсэн тохиолдлууд бүртгэгдэв.

- Сонгогчдын боловсролд чиглэсэн мэдээлэл сонгуулийн сурталчилгааны эхний долоо хоногт хамгийн олон давтамжтай байсан бол сурталчилгааны сүүл үе гэхэд хоёр дахин буурчээ. Сонгуулийн сурталчилгааны эхэн үед телевизүүд сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэлд илүүтэй ач холбогдол өгч түлхүү нэвтрүүлж байсан бол сонгуулийн сурталчилгааны сүүлийн долоо хоногуудад аажмаар буурч харин төлбөртэй болон далд сурталчилгааны мэдээлэлд дийлэнх цагаа зориулжээ.

- Сонгуулийн сурталчилгааны хугацаанд цацагдсан далд сурталчилгааны дийлэнх нь (90%) нь эрх баригч нам болон Засгийн газартай холбоотой мэдээлэлд хамаарч байна. МУ-ын Засгийн газар болон түүний харъяа яам, агентлагуудын үйл ажиллагаа, ерөнхий сайд болон эрх баригч намын хэрэгжүүлж буй ажлуудыг дэмжин магтаж сайшаасан нэг талын тэнцвэргүй мэдээллийн тал нь (50%) МҮОНТ-ээр цацагдсан бол ТВ9 телевиз эрх баригч намын, засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилсэн нэг талын байр суурь бүхий мэдээллийн 79%-ийг нэвтрүүлжээ.

- Харин UBS, MN25 суваг телевиз нийслэлийн засаг захиргааг дэмжсэн мэдээллийг

түлхүү гаргасан бол NTV телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэлд цагаа илүүтэй зориулжээ. Тодруулбал, NTV телевиз “Хэрсүү сонголт” гэсэн 20 минутын сонгогчдод зориулсан буланг мэдээллийн хөтөлбөр дундуураа явуулж байсан нь онцлог байв.

- Мониторингийн хугацаанд цацагдсан далд сурталчилгааны **82%** нь нэг талын байр суурийг илэрхийлэхдээ илт магтан сурталчилсан, **18%** нь нэг талын байр суурийг илэрхийлэхдээ илт муулан шүүмжилсэн агуулгатай мэдээлэл байв. Эндээс харахад телевизүүд сонгуулийн кампанит ажлын үеэр ухуулан сурталчлах, ятган үнэмшүүлэх, тархи угаах зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйд харш үйлдлийг мэдээллийн хөтөлбөр дундуураа явуулсан байна.

- Сэтгүүл зүйн тэнцвэрт байдлыг хангах эх сурвалжийн гурван түвшинг хангасан мэдээ мэдээлэл цацагдаагүй нь сонгуулийн үеийн сэтгүүл зүйн тэнцвэрт байдал хангагдсангүй.

- Сонгуулийн хугацаанд нийт мэдээллийн 90 орчим хувь нь сонгуулийн ил болон далд сурталчилгаа байсан бөгөөд асуудал хөндсөн, задлан шинжилсэн редакцын бүтээлүүд тун ховор байсан тул телевизүүд мэдээллийн хөтөлбөрөөрөө сэтгүүл зүйн үүргээ биелүүлж чадсангүй. Үүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг нь УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 48.1.8-т заасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн чансаа тогтоох аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулахыг хориглосон нь аналитик сэтгүүл зүйн сэтгүүл зүйн үйл ажиллагаанд ихээхэн саад учруулсан байна.

- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.5-т Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана, ёс зүйн зарчмын 9-т Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана, 9.1-т Далд сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана гэсэн заалтууд сонгуулийн үед мөрдөгдсөнгүй.

Дөрөв. ЗӨВЛӨМЖ

Энэхүү мониторингийн дүгнэлтүүдэд тулгуурлан дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Нэг. Хууль тогтоогч, бодлого боловсруулагч, хуульч, эрх зүйчдэд хандан:

- Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн томъёоллыг эргэн харж гүтгэх шинжийг агуулсан “санаатайгаар худал баримтыг зохиож нэр төрд халдах”-ыг санамсаргүйгээр худал мэдээлэл тарааснаас ялгаж томъёолох, мөн “илт худал мэдээлэл”, “худал мэдээлэл” зэрэгт хууль зүйн тайлбар хийх;

- Эрүүгийн хуулийн 14.8 “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” зүйлийг хасах;

- Сонгуулийн кампанит ажлын үеэрх дүн шинжилгээ бүхий аналитик сэтгүүл зүйн үйл ажиллагаанд саад болж буй УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 48.1.8-т заалтыг эргэж харах;

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан “илт худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг зөвхөн Иргэний хуулийн 21, 497, 511 дүгээр зүйлийн дагуу Иргэний хэргийн шүүх, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын дагуу Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр тус тус шийдвэрлүүлдэг эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх;

- Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбарын сайн дурын санаачилга бүхий хараат бус хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог улам бэхжүүлэн хөгжүүлэхэд талуудын ойлголцол, хамтын ажиллагаа болон бодлогын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Гэм хорын эрх зүйн үүднээс Иргэний хэргийн шүүхэд нэр төр, алдар хүнд хохирсон гэж үзэж шүүхэд нэхэмжлэл гаргаж буй иргэд нь хохирсон гэдгээ өөрсдөө нотлох үүргийг оногдуулах замаар Иргэний хуулийг шинэчлэн сайжруулах;

- Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйл дэх Хэвлэл мэдээллийн зөвлөлийн чиг үүргийг хасах, эсхүл одоогийн Хэвлэл мэдээллийн зөвлөл нь сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой гомдлыг шийдвэрлэдэг байх зохицуулалтыг тус хуульд тусгах;

- ТВ-ийн мэдээллийн хөтөлбөр нь тухайн редакцын сэтгүүл зүйн үйл ажилагааны гол цөм бөгөөд сонгогчдод тэнцвэртэй мэдээлэл хүргэх хамгийн чухал нэгж хэсэг юм. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 46.14-т мэдээллийн хөтөлбөрт нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй гэсэн заалт нь мэдээллийн хөтөлбөр дэх сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагааг саармагжуулж, улмаар сонгуульд нэр дэвшигч талуудад төлбөрийн чадамжаас хамаарсан тэгш бус байдлыг үүсгэж буйг анхааралдаа авах;

Хоёр. Хэвлэл мэдээллийн байгууллагын эрхлэн гаргагч, редактор, сэтгүүлчдэд хандан:

- Үндсэн хуулиар баталгаажуулсан хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйл: Үзэл бодлоо илэрхийлэх хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах заалтын дагуу гомдлоо цагдаагийн байгууллагад гарган шийдвэрлүүлж байх;

- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг үндэслэлгүйгээр эрх бүхий байгууллагад хандаж шалгуулсан тохиолдолд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь зохих байгууллагад үндэслэлгүйгээр нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан талаар гомдол, нэхэмжлэлээ гаргадаг сайн жишгийг тогтоох;

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан “илт худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг зөвхөн Иргэний хуулийн 21, 497, 511 дүгээр зүйлийн дагуу Иргэний хэргийн шүүх, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын дагуу Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр тус тус шийдвэрлүүлдэг байхын төлөө нөлөөллийн ажил хийх;

- Ардчилсан сонгуулийн үйл явцад чөлөөт хэвлэл, сэтгүүл зүйн гүйцэтгэж буй үүргийн өнөөгийн байдалд нухацтай хандаж, хэвлэл мэдээллийн салбар дотроо энэ талаарх судалгааны үр дүнд тулгуурласан бүтээлч шүүмжлэлийг өрнүүлэх;

- Хэвлэл мэдээллийн байгууллагууд “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах редакцын

бодлого"-ыг редакцдаа мөрдөж, ардчилсан сонгуулийн үйл явцад хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаар сэтгүүлчиддээ давтан сургалт авах, энэ талын нөлөөллийн ажлуудыг идэвхжүүлэх;

- Сонгуулийн үед хэвлэл мэдээлэл мэргэжлийн түвшинд ажиллах боломжийг эрх зүйн хувьд хэр олгож буйд дүгнэлт хийж, саад болж буй хуулийн холбогдох заалтуудын талаар байр сууриа илэрхийлэх, хуулинд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулахын төлөө мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах;

- ОНРТ-ийн тухай хуулийн дагуу МҮОНРТ-ийн ардчилсан сонгуульд гүйцэтгэх үүргийг тодотгож, тус ТВ-ийг тэнцвэртэй бөгөөд шударгаар, хараат бусаар ажиллуулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

- Телевизийн редакцууд сонгуулийн кампанит ажлын үеийн мэдээллийн хөтөлбөрийнхөө бүтцэд анхаарлаа хандуулж, төлбөрт мэдээлэл болон редакцын бүтээлийг тэнцвэрийг барих, нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийн ялгаа заагийг үзэгчиддээ ойлгомжтой харуулж хэвших;

- Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэлд юу багтах, редакцын бодлогод хэрхэн тусгах, сэтгүүлдээ энэ талаар бэлтгэхэд анхаарч ажиллах;

- Телевизийн мэдээллийн хөтөлбөрт аливаа хэлбэрийн далд сурталчилгаа явуулахаас эрс татгалзаж, сонгуулийн үед хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа чанд мөрдөж ажиллах;

Тав. Ашигласан эх сурвалжийн жагсаалт

А/ Эрх зүйн зохицуулалт:

1. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
2. Иргэний хууль
3. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/
4. Сонгуулийн тухай хууль
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/
7. ХХЗХ, ЦЕГ-ын хамтарсан журам

Б/ Холбогдох статистик, мэдээлэл:

8. Тагнуулын ерөнхий газрын 2020.08.31-ний өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 1145 тоот албан бичиг
9. Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын 2020.09.16-ны өдрийн 16/1069 тоот албан бичиг
10. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2020.09.17-ны өдрийн 86/2731 тоот албан бичиг
11. Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын 2020.10.09-ний өдрийн 04/1767 тоот албан бичиг
12. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас 2020.10.26-ны өдрийн 2/5569 тоот албан бичиг болон хавсралт хүснэгт
13. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн албан бичгүүд, 2020.09
14. Шүүхийн шийдвэрийн цахим сан shuukh.mn
15. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим
16. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын шийдвэрүүд 2020 он

Зургаа. Хавсралт

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид хамаарах хуулийн заалтууд

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах

1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмж ээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

[/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.2 дугаар зүйл. Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах

1.Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

14.3 дугаар зүйл. Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах

1.Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун

тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах

1. Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Энэ гэмт хэргийг төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан үйлдсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих

1. Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ЗӨРЧИЛ

/Энэ бүлгийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн./

17.1 дүгээр зүйл. Сонгуулийн хуулийг зөрчих

- */Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

1. Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13. Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.7. Харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

19. Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

/Энэ заалтыг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./

10.4.13. олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх;

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ

13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

13.3. Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг

нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно.

14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг

14.1. Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ.

14.2. Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

46 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах

46.1. Сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлэг /цаашид “сурталчилгааны нэвтрүүлэг” гэх/-ийг радио, телевизээр нэвтрүүлж болно.

46.2. Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ.

46.3. Олон нийтийн радио, телевиз нь нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг олгох саналаа Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхдээ нам, эвслээс нэр дэвшигчдэд намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, бие даан нэр дэвшигчийн тухайд Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно.

46.4.Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзсэний үндсэн дээр сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална.

46.5.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сурталчилгааны нэвтрүүлгийг гэрээний үндсэн дээр нэвтрүүлнэ.

46.6.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна.

46.7.Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно.

46.8.Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.

46.9.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ:

46.9.1.сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар тогтоосон нарийвчилсан цагийн хуваарь;

46.9.2.ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж байсан гурваас доошгүй зар сурталчилгаа нэвтрүүлэх гэрээ;

46.9.3.сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх дундаж үнийн талаарх мэдээлэл.

46.10.Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглоно.

46.11.Радио, телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн үндсэн сувгаар нэвтрүүлнэ.

46.12.Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүрэгтэй.

46.13.Радио, телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ бодит, тэнцвэртэй, нэг талыг барихгүй, хараат бус байх зарчмыг баримтална.

46.14.Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглоно.

46.15.Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.

46.16.Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.

46.17.Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байна.

46.18.Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно.

46.19.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.

46.20.Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ хуульд нийцүүлэн батална.

46.21.Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн баталсан хуваарь, цаг болон сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх зөвшөөрөл олгосон радио, телевизийн жагсаалтыг сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хүргүүлж, өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлнэ.

46.22.Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавьж ажиллана.

46.23.Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуульд заасан зөрчил гаргуулахгүй байх, гарсан зөрчлийг зогсоох арга хэмжээг цагдаагийн болон сонгуулийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

46.24.Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх талаар энэ хуулийн 46.20-д заасан журам зөрчсөн бол эхний удаад сануулах арга хэмжээ авах, эсхүл радио, телевизийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг санал авах өдөр хүртэл цуцлах тухай шийдвэр гаргана.

46.25.Энэ хуулийн 46.10-т заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно.

46.26.Энэ хуулийн 39.1-д заасан сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт энэ хуулийн 46.6, 46.7, 48.9-д заасныг зөрчсөн бол телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно.

48 дугаар зүйл. Хууль бус сурталчилгааг хориглох

48.1. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

48.1.1. мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх;

48.1.2. нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;

48.1.3. сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амрах, сувилуулах;

48.1.4. ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;

48.1.5. хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;

48.1.6. сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

48.1.7. хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох

зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах.

48.2.Улс төрийн намаас зөвхөн гишүүдийнхээ хүрээнд зохион байгуулсан сургалт, уулзалтыг сонгогчдын саналыг татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамааруулахгүй.

48.3.Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.

48.4.Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.

48.5.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

48.5.1. энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;

48.5.2. зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;

48.5.3. сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

48.5.4. энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

48.5.5. оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;

48.5.6.олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.

48.6.Сонгуулийн мөрийн хөтөлбөрт туссан иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр, сүм хийдийн

харилцаа, шашны талаарх бодлого, үзэл баримтлалыг сонгогчдод тайлбарлан таниулах үйл ажиллагааг шашны зан үйл ашигласан гэж үзэхгүй.

48.7. Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.

48.8. Дахин болон нэмэлт санал хураалт дуусталх хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно.

48.9. Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхийг хориглоно.

48.10. Сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор тэдгээрийн нэрийн өмнөөс аливаа этгээд санаатайгаар хууль бус сурталчилгаа хийхийг хориглоно.

48.11. Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.9-д заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд энэ хуулийн 48.8, 48.9-д заасныг зөрчсөн тохиолдолд радио, телевизийн байгууллагын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

48.12. Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 46.13, 48.1.7, 48.7-д хяналт тавьж ажиллана.

48.13. Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад эхний удаа сануулах арга хэмжээ авч болно.

48.14. Энэ хуулийн 48.12-т заасны дагуу зөрчлийг шалгах хугацаанд шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санал хураалтын дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг нь зогсоох тухай дүгнэлтийг зөвшөөрөл олгосон байгууллагад нь хүргүүлэх арга хэмжээг авч болно.

